

2025 он 11 сарын 04 өдөр

Дугаар 25/10

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Хөвсгөл” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2025 оны 11 сарын 4-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. МПЕРС ХХК-ийн нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 5,000 ширхэг энгийн хувьцааг 5,000,000 төгрөгөөр Ард Венчурс ХХК-аас худалдан авахыг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ.**
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан шаардлагатай бүхий л баримт бичиг, холбогдох гэрээ, хэлцэлд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Ч.Ганхуяг)-д **ОЛГОСУГАЙ.**
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан хэрэгжилтийг ханган, тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ч.Ганхуяг)-д, холбогдох төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Ерөнхий нягтлан бодогч (Б.Уянга)-д тус тус үүрэг **БОЛГОСУГАЙ.**

ДАРГА



П.БАТБАЯР

2025 он 11 сарын 04 өдөр

Дугаар 25/11

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалт, 76.1.8 дахь заалт, “Хөвсгөл” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2025 оны 11 сарын 04-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Ард венчурс” ХХК /РД:6511708/-ийн оноосон нэрийг “Иксгрууп” болгон өөрчлөхийг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ.**
2. “Ард венчурс” ХХК-ийн нэрний өөрчлөлттэй холбогдуулан компанийн дүрэмд орох өөрчлөлтийг энэхүү тогтоолын хавсралтаар **БАТАЛСУГАЙ.**
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, “Ард венчурс” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн шийдвэр, холбогдох баримт бичигт гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Ч.Ганхуяг)-д **ОЛГОСУГАЙ.**

ДАРГА



П.БАТБАЯР

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Компанийн бэлгэдэл тэмдэг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дах заалт, “Хөвсгөл” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2025 оны 11 сарын 04 одрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн бэлгэдэл тэмдгийг Хавсралт 1-ээр баталж, компанийн нэрийн өөрчлөлтийг Улсын бүртгэлд бүртгүүлснээр бэлгэдэл тэмдгийг албан бичиг бусад баримт материалд **АШИГЛАСУГАЙ.**
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан хэрэгжилтийг ханган, тайлагнаж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Э.Халиунгоо)-д үүрэг **БОЛГОСУГАЙ.**

ДАРГА



П.БАТБАЯР